



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 09 сарын 02 өдөр

Дугаар А/487

Хэрлэн сум

“Залуус хороолол”-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, 35.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэрлэн сумын 3 дугаар багт баригдах “Залуус хороолол”-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг холбогдох хууль тогтоомж, журам заавар, стандарт, норм дүрмийн дагуу зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн
ахлагч:

Аймгийн Засаг даргын орлогч

Нарийн бичгийн
дарга:

Аймгийн ерөнхий архитектор

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын захирагч

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Эдийн засгийн бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн

“Хэнтий Ус” ХХК-ийн гүйцэтгэх захирал

Мэдээлэл холбоо сүлжээ ХХК-ийн дарга

Багануур зүүн өмнөд бүсийн Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн харьяа Хэнтий Цахилгаан түгээх сүлжээний дарга

Чингис хотын архитектор

2.Төлөвлөгөө боловсруулах ажлыг шуурхай зохион байгуулж, үр дүнг танилцуулахыг ажлын хэсгийн ахлагчид үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ



